

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/144/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМАН ДАХЬ
ПОЛИТЕХНИКИЙН КОЛЛЕЖИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasurenb@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.25 № 01/186
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ
СУМ ДАХЬ ПОЛИТЕХНИКИЙН
КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ
Э.АМАРТҮВШИН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 254 дүгээр тогтоолоор ерөнхий боловсрол эзэмшиж байгаа мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 2.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 6.3 мянган төгрөг болгон шинэчлэн тогтоосон байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Баянчандмань сум дахь Политехникийн коллежийн дотуур байрны их засварын ажлыг 134,269.2 мянган төгрөгөөр гүйцэтгүүлж, тус сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Үндсэн хөрөнгө бүртгэх тухай” А/656 захирамжаар бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

4126020189

**Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 80 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	530,172,198.74	693,661,042.69
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	66,411,983.06	191,503,240.76
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	66,411,983.06	191,503,240.76
3121	Төгрөг	66,411,983.06	191,503,240.76
31211	Төрийн сангийн харилцах	66,411,983.06	191,503,240.76
33	АВЛАГА	12,812,347.31	21,103,601.56
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	27,999.50	296,643.94
335	Бусад авлага	12,784,347.81	20,806,957.62
3351	Байгууллагаас авах авлага	10,768,892.62	18,704,492.62
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,015,455.19	2,102,465.00
35	БАРАА МАТЕРИАЛ	450,947,868.37	481,054,200.37
351	Түүхий эд материал	225,571,021.22	271,605,804.22
35110	Тусгай зориулалттай материал	224,069,241.22	269,266,211.22
35130	Эм боох материал	1,501,780.00	2,339,593.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	439,000.00	-
354	Хангамжийн материал	194,280,207.15	176,962,706.15
35410	Бичиг хэргийн материал	1,918,976.00	2,302,272.00
35420	Аж ахуйн материал	35,527,354.98	36,884,579.98
35450	Барилгын засварын материал	58,545,490.65	52,867,940.65
35460	Хүнсний материал	52,039,790.12	33,009,968.12
35470	Бусад хангамжийн материал	46,248,595.40	51,897,945.40
35500	Биологийн хөрөнгө	21,017,640.00	20,135,690.00
35600	Мал амьтад	9,640,000.00	12,350,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,260,139,323.12	5,203,751,513.98
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,260,139,323.12	5,203,751,513.98
392	Биет хөрөнгө	4,652,660,613.19	4,596,936,324.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,547,815,440.47	3,702,270,564.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,262,595,211.20)	(1,524,607,440.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	386,842,800.00	397,132,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(290,946,807.65)	(29,933,992.53)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,144,720,705.90	2,129,693,781.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(787,566,896.10)	(932,969,963.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	179,429,553.00	186,448,629.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(95,461,431.64)	(76,632,346.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,398,084,897.22	1,410,972,647.22
39215	Хуримтлагдсан элэгдэл	(592,620,557.18)	(690,342,476.26)
39217	Ном	24,958,120.37	24,904,120.37
393	Биет бус хөрөнгө	607,478,709.93	606,815,189.86
39301	Програм хангамж	4,367,600.00	4,312,600.00

**Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,168,890.07)	(2,777,410.14)
39303	Бусад биет бус хөрөнгө	605,280,000.00	605,280,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,790,311,521.86	5,897,412,556.67
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,196,760.54	50,204,335.14
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,196,760.54	50,204,335.14
413	Өглөг	1,196,760.54	50,204,335.14
4136	Бусад өглөг	5,723.00	19,668,696.59
41361	Байгууллагад төлөх өглөг	5,723.00	19,638,692.45
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	30,004.14
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,789,114,761.32	5,847,208,221.53
51	Засгийн газрын хувь оролцоо	5,789,114,761.32	5,847,208,221.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,621,251,717.46	1,621,251,717.46
51101	Өмч: - төрийн	1,034,401,717.46	1,034,401,717.46
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	586,850,000.00	586,850,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,494,542,692.41	1,552,636,152.62
51210	Өмнөх үеийн үр дүн	1,494,542,692.41	1,494,542,692.41
51220	Тайлант үеийн үр дүн	-	58,093,460.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,673,320,351.45	2,673,320,351.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,790,311,521.86	5,897,412,556.67

**Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,441,205,299.00	5,223,287,491.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	450,710,199.00	558,961,188.66
120	Нийтлэг татварын бус орлого	450,710,199.00	558,961,188.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	450,710,199.00	38,458,278.66
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,210,500.00	6,550,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,972,370.00	31,908,278.66
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	51,348,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	364,179,329.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	516,412,910.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	4,090,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,990,495,100.00	4,664,326,302.91
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,261,989,200.00	3,905,706,802.91
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,261,989,200.00	3,905,706,802.91
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	728,505,900.00	758,619,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	728,505,900.00	758,619,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,370,623,412.50	5,168,414,273.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,370,623,412.50	5,168,414,273.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,213,375,494.90	5,034,426,123.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,092,226,740.02	2,470,486,935.08
210101	Үндсэн цалин	1,135,389,916.48	1,290,534,502.15
210102	Нэмэгдэл	680,863,448.64	926,750,770.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	156,277,000.00	159,390,000.00
210104	Урамшуулал	119,696,374.90	93,811,662.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	261,021,286.80	304,865,052.03
210201	Тэтгэврийн даатгал	179,339,604.06	208,764,152.55
210202	Тэтгэмжийн даатгал	21,011,459.53	24,986,029.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,462,829.78	12,371,574.74
210204	Ажилгүйдлийн даатгал	10,036,998.72	12,075,096.48
210205	Эрүүл мэндийн даатгал	40,170,394.71	46,668,198.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	671,730,280.40	733,029,915.94
210301	Гэрэл, цахилгаан	63,314,080.40	94,739,545.94
210302	Түлш, халаалт	608,416,200.00	638,290,370.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,801,983.19	41,869,600.00
210401	Бичиг хэрэг	1,031,845.00	1,525,704.00
210402	Тээвэр, шатахуун	18,222,700.95	22,088,626.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,760,507.24	553,515.00
210404	Ном, хэвлэл	-	54,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,920,200.00	5,311,930.00

**Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,756,730.00	10,809,875.00
210408	Бараа материал акталсны зардал	1,110,000.00	1,525,950.00
2105	Нормативт зардал	231,403,084.00	436,210,365.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,425,689.00	788,863.00
210502	Хоол, хүнс	223,977,395.00	435,421,502.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,052,690.00	59,070,250.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,573,000.00	8,402,900.00
210604	Урсгал засвар	53,479,690.00	50,667,350.00
2107	Томилолт, зочны зардал	8,597,572.00	-
210702	Дотоод албан томилолт	8,597,572.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,243,029.08	133,193,407.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,942,428.08	133,193,407.66
210803	Даатгалын үйлчилгээ	452,025.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,303,342.00	-
210807	Газрын төлбөр	545,234.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	788,298,829.41	855,700,597.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,255,800.00	63,027,436.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	201,494,327.35	173,443,950.45
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	487,548,702.06	619,229,211.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	157,247,917.60	133,988,150.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	157,246,540.00	133,860,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,862,540.00	62,372,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	135,384,000.00	71,488,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,000,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,377.60	126,850.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,377.60	126,850.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	70,581,886.50	54,873,218.17
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	6,910,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	6,910,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	3,689,757.96
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,689,757.96
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	3,220,242.04
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	70,581,886.50	58,093,460.21

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,076,613,820.00	4,702,905,571.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,118,720.00	38,579,268.35
120	Нийтлэг татварын бус орлого	86,118,720.00	38,579,268.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	86,118,720.00	38,579,268.35
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,210,500.00	6,550,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,560,220.00	32,029,268.35
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	51,348,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,990,495,100.00	4,664,326,302.91
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,261,989,200.00	3,905,706,802.91
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,261,989,200.00	3,905,706,802.91
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	728,505,900.00	758,619,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	728,505,900.00	758,619,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,966,911,136.94	4,532,362,063.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,966,911,136.94	4,532,362,063.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,809,663,219.34	4,398,373,913.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,095,625,873.00	2,459,102,247.86
210101	Үндсэн цалин	1,177,980,772.28	1,302,112,662.77
210102	Нэмэгдэл	642,246,558.91	855,498,758.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	155,702,166.91	207,679,163.64
210104	Урамшуулал	119,696,374.90	93,811,662.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	258,689,074.60	317,272,576.40
210201	Тэтгэврийн даатгал	178,128,200.00	215,758,604.92
210202	Тэтгэмжийн даатгал	20,956,200.00	25,383,453.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,478,200.00	12,691,676.76
210204	Ажилгүйдлийн даатгал	9,947,174.60	12,687,768.24
210205	Эрүүл мэндийн даатгал	39,179,300.00	50,751,072.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	683,505,900.00	703,619,499.94
210301	Гэрэл, цахилгаан	70,579,700.00	76,793,368.44
210302	Түлш, халаалт	608,416,200.00	623,353,300.00
210303	Цэвэр, бохир ус	4,510,000.00	3,472,831.50
2105	Нормативт зардал	243,775,170.00	416,519,160.00
210502	Хоол, хүнс	243,775,170.00	416,519,160.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,708,772.40	61,283,750.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	23,710,150.00	17,620,600.00
210604	Урсгал засвар	44,998,622.40	43,663,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,477,185.00	157,422,134.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,477,185.00	157,422,134.30

**Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	394,881,244.34	283,154,545.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	202,849,106.34	137,019,282.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	192,032,138.00	146,135,263.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	157,247,917.60	133,988,150.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	157,246,540.00	133,860,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,862,540.00	62,372,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	135,384,000.00	71,488,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,000,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,377.60	126,850.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,377.60	126,850.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	109,702,683.06	170,543,507.70
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	43,291,200.00	45,452,250.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	43,291,200.00	45,452,250.00
2200	Дотоод эх үүсвэрээр	43,291,200.00	45,452,250.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	43,291,200.00	45,452,250.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(43,291,200.00)	(45,452,250.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	66,411,483.06	125,091,257.70
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	500.00	66,411,983.06
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	66,411,983.06	191,503,240.76

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан **/төгрөгөөр/**

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,621,251,717.46	2,673,320,351.45	2,371,852,746.41	6,666,424,815.32
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,621,251,717.46	2,673,320,351.45	2,371,852,746.41	6,666,424,815.32
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(585,335,369.45)	(585,335,369.45)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,621,251,717.46	2,673,320,351.45	1,494,542,692.41	5,789,114,761.32
2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,621,251,717.46	2,673,320,351.45	1,494,542,692.41	5,789,114,761.32
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,621,251,717.46	2,673,320,351.45	1,494,542,692.41	5,789,114,761.32
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	58,093,460.21	58,093,460.21
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,621,251,717.46	2,673,320,351.45	1,552,636,152.62	5,847,208,221.53

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,788,723,900.00	4,702,778,721.20	85,945,178.80	98.21
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,938,563,300.00	3,905,706,802.91	32,856,497.09	99.17
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,938,563,300.00	3,905,706,802.91	32,856,497.09	99.17
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	758,619,500.00	758,492,649.94	126,850.06	99.98
132001	Орон нутгийн төсвөөс	758,619,500.00	758,492,649.94	126,850.06	99.98
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	91,541,100.00	38,579,268.35	52,961,831.65	42.14
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,395,000.00	6,550,000.00	33,845,000.00	16.21
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,698,000.00	32,029,268.35	(12,331,268.35)	162.60
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	31,448,100.00		31,448,100.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,788,723,900.00	4,577,686,963.50	211,036,936.50	95.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,788,723,900.00	4,577,686,963.50	211,036,936.50	95.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,640,153,100.00	4,443,826,163.50	196,326,936.50	95.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,528,395,100.00	2,459,102,247.86	69,292,852.14	97.26
210101	Үндсэн цалин	1,497,418,600.00	1,292,575,325.66	204,843,274.34	86.32
210102	Нэмэгдэл	822,477,700.00	865,036,095.76	(42,558,395.76)	105.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	208,498,800.00	207,679,163.64	819,636.36	99.61
210104	Урамшуулал	-	93,811,662.80	(93,811,662.80)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	316,049,500.00	317,272,576.40	(1,223,076.40)	100.39
210201	Тэтгэврийн даатгал	214,913,600.00	215,758,604.92	(845,004.92)	100.39
210202	Тэтгэмжийн даатгал	25,284,000.00	25,383,453.52	(99,453.52)	100.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,642,000.00	12,691,676.76	(49,676.76)	100.39
210204	Ажилгүйдлийн даатгал	12,642,000.00	12,687,768.24	(45,768.24)	100.36
210205	Эрүүл мэндийн даатгал	50,567,900.00	50,751,072.96	(183,172.96)	100.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	703,619,500.00	703,619,499.94	0.06	100.00
210301	Гэрэл, цахилгаан	71,626,200.00	76,793,368.44	(5,167,168.44)	107.21
210302	Түлш, халаалт	623,353,300.00	623,353,300.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	8,640,000.00	3,472,831.50	5,167,168.50	40.19
2105	Нормативт зардал	499,566,400.00	416,519,160.00	83,047,240.00	83.38
210502	Хоол, хүнс	499,566,400.00	416,519,160.00	83,047,240.00	83.38
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	88,183,000.00	79,743,750.00	8,439,250.00	90.43
210603	Хөдөлмөр хамгаалалтын хэрэгсэл	17,624,600.00	17,620,600.00	4,000.00	99.98
210604	Урсгал засвар	70,558,400.00	62,123,150.00	8,435,250.00	88.05
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	163,268,700.00	161,922,134.30	1,346,565.70	99.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	163,268,700.00	161,922,134.30	1,346,565.70	99.18
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	341,070,900.00	305,646,795.00	35,424,105.00	89.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	182,005,300.00	146,581,282.00	35,424,018.00	80.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	159,065,600.00	159,065,513.00	87.00	100.00

**Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	148,570,800.00	133,860,800.00	14,710,000.00	90.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	148,570,800.00	133,860,800.00	14,710,000.00	90.10
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	62,372,800.00	62,372,800.00	-	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	86,198,000.00	71,488,000.00	14,710,000.00	82.93
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		66,411,483.06		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		191,503,240.76		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 5,347,649.3 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан-үндсэн хөрөнгө (120017), үнэ төлбөргүй хүлээн авсан-бараа материал (120018) салгаж тайлагнаагүй, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого (120045) дансанд 527,536.7 мянган төгрөгийг бүртгэсэн.

Санхүүгийн мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан 19,654.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн биет ба биет бус хөрөнгийн зардалд тайлагнаагүй.

Хаан зоос ХХК-наас худалдан авсан 980.0 мянган төгрөгийн энгэрийн тэмдгийг шууд зардалд тайлагнасан.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 4,788,723.9 мянган төгрөгийн батлагдсан төсвийг тайлагнаагүй.

Санхүүгийн үр дүнгийн тайланд 10,754.7 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалингийн зардалд бүртгэснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-т "нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж тус тус заасны дагуу залруулсан.

Аудитаар нийт 18,744.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 17,162.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1,581.3 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 18,744.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 49,082.1 мянган төгрөгөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1."Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан бүсийн аварга шалгаруулах спортын наадам"-д 22 багш, ажилчинд 13,362.8 мянган төгрөгийн албан томилолтын зардал олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-т "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахын хориглох" гэж заасныг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Спорт, биеийн тамир тэмцээн уралдаанд оролцохдоо албан томилолтын зардал гаргахгүй байх зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

2."Сэлэнгэ, Ховд аймагт зохион байгуулагдах бүсийн аварга шалгаруулах спортын наадам"-д оролцох баг тамирчдын 3,800.0 мянган төгрөгийн бооцооны төлбөрийг төсвийн зардлаас зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-т "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж заасныг тус тус зөрчсөн.

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Аудитын газарт 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2026 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр ирүүлж, Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "төсвийн шууд захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5-т "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-т "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж, хуулийн хугацаанд нь ирүүлж байх.

2. Зардлын данстай асуудалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд ажилтны цалин хөлсийг нийгмийн даатгалын системд тайлагнахдаа ажилтны даатгалын кодыг зөрүүтэй тайлагнаснаас 1,581.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл илүү тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасны зөрчсөн.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын газарт ажилтны кодын зөрүүг залруулах тайлан хүргүүлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан-үндсэн хөрөнгө (120017), үнэ төлбөргүй хүлээн авсан-бараа материал (120018) салгаж тайлагнаагүй, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /120045/ дансанд 527,536.7 мянган төгрөгийг бүртгэсэн.	1	527,536.7			1	527,536.7	1	527,536.67		
2	Санхүүгийн мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан 19,654.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн биет ба биет бус хөрөнгийн зардалд тайлагнаагүй.	1	19,654.0			1	19,654.0	1	19,654.00		
3	Хаан зоос ХХК-наас худалдан авсан 19,654.0 мянган төгрөгийн энгэрийн тэмдгийг шууд зардалд тайлагнасан..	1	980.0			1	980.0	1	980.0		
4	Төсвийн гүйцэтгэлийн тайланд 4,788,723.9 батлагдсан төсвийг тайлагнаагүй.	1	4,788,723.9	1	4,788,723.9			1	4,788,723.9		
5	Санхүүгийн үр дүнгийн тайланд 10,754.7 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалингийн зардалд бүртгэсэн.	1	10,754.7			1	10,754.7	1	10,754.7		
	Дүн	5	5,347,649.3	1	4,788,723.9	4	558,925.4	5	5,347,649.3		

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	"Сэлэнгэ, Ховд аймагт зохион байгуулагдах бүсийн аварга шалгаруулах спортын наадам"-д оролцох баг тамирчдын 3,800.0 мянган төгрөгийн бооцооны төлбөрийг төсвийн зардлаас зарцуулсан.	1	3,800.0			1	3,800.0								
2	"Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан бүсийн аварга шалгаруулах спортын наадам"-д 22 багш, ажилчинд 13,362.8 мянган төгрөгийн албан томилолтын зардал олгосон.	1	13,362.8			1	13,362.8								
3	Тайлант онд ажилтны цалин хөлсийг нийгмийн даатгалын системд тайлагнахдаа ажилтны даатгалын кодыг зөрүүтэй тайлагнаснаас 2,235.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл илүү тайлагнасан.	1	1,581.3					1	1,581.3						
4	Аудитын газарт 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2026 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр ирүүлж, Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1						1							
	Нийт дүн	4	18,744.1			2	17,162.8	2	1,581.3						

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 145 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 17 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 742,392.9 мянган төгрөгийн 19 гүйлгээ, зарлагын 423,749.4 мянган төгрөгийн 22 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 1,660,077.7 мянган төгрөгийн 17 гүйлгээ, зарлагын 324,079.2 мянган төгрөгийн 17 гүйлгээ байршуулаагүй.	1	3,150,299.3			1	3,150,299.3		-
Дүн	1	3,150,299.3			1	3,150,299.3		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	3,150,299.3			1	3,150,299.3		



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 54-20810579-ТӨА-2026/144/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сэлэнгэ, Ховд аймагт зохион байгуулагдсан бүсийн аварга шалгаруулах спортын наадамд оролцох баг тамирчдын 3,800,000 (гурван сая найман зуун мянган) төгрөгийн бооцооны төлбөрийг төсвийн зардлаас зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-т "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-т "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн захирал Э.Амартүвшиг, нягтлан бодогч Д.Чанчалдулам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 53-20810579-ТӨА-2026/144/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллеж нь тайлант онд нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 145 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 17 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 742,392.9 мянган төгрөгийн 19 гүйлгээ, зарлагын 423,749.4 мянган төгрөгийн 22 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 1,660,077.7 мянган төгрөгийн 17 гүйлгээ, зарлагын 324,079.2 мянган төгрөгийн 17 гүйлгээ байршуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.10-т "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгах аргаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн захирал Э.Амартүвшин, нягтлан бодогч Ч.Баярцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 58-20810579-ТӨА-2026/144/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан бүсийн аварга шалгаруулах спортын наадамд 22 багш, ажилчинд 13,362,800 /арван гурван сая гурван зуун жаран хоёр мянга найман зуун/ төгрөгийн албан томлолтын зардал олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-т "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-т "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй, зөрчлийн давтан гаргахгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехникийн коллежийн захирал Э.Амартүвшиг, нягтлан бодогч Д.Чанчалдулам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn